



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2008 №1 303 (16)



Улаанбаатар хот

Тус сэтгүүл нь анх 1996 оноос "Алтан аргамж" нэрээр, 2002 оноос "Олон улсын харилцаа" нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as "Altan argamj" and since 2002 as "World Affairs"

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (тэр.проф.доктор Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (проф.доктор Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (тэр.проф.доктор Sc.D)
Ц.Гүрбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
Б.Хулдорж (проф.доктор Ph.D)
Д.Намсрай (дэд проф.доктор Ph.D)
Д.Отгончимэг (дэд проф.доктор Ph.D)
Б.Энхбаяр (проф.доктор Ph.D)
Ж.Баттогтох (доктор Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн салбар – 46 а, хайрцаг-6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 354610; 354611; 354618
Факс: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Assistant Editor:

D.Tungalag (Prof.Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof. Sc.D)
Ts.Gurbadam (Prof. Sc.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
B.Khuldorj (Prof.Ph.D)
D.Namsrai (Prof.Ph.D)
D.Otgonchimeg (Prof.Ph.D)
B.Ekhbayar (Prof.Ph.D)
J.Battogtokh (Ph.D)

Publishing design:

S.Oyunsuren

Editorial Address:

School of Foreign Service
National University of Mongolia
P.O. – 46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel: 354610; 354611; 354618
Fax: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

АГУУЛГА

I. Монгол улсын гадаад бодлого, олон улсын харилцаа

<i>Н.Алтанцэцэг</i>	
БНХАУ: Хөгжил рүү чиглэсэн гадаад бодлогоос дэлхий рүү чиглэсэн гадаад бодлого	5
<i>Баасанхүү</i>	
Олон улсын харилцааны онол ба экологийн аюулгүй байдлын харилцан хамаарлын асуудалд	13
<i>Ж. Баттөр</i>	
1913 оны Монгол-Төвдийн найрамдлын гэрээ	20
<i>А.Батцэцэг</i>	
БНХАУ-ын коммунист намын ерөнхий нарийн бичгийн дарга Ху Жин Тао улиран сонгогдсон ХКН-ын XVII их хурлын үр дүн	31
<i>С. Баясгалан</i>	
Дэлхийн цөмийн зэвсэггүй бүсүүд	38
<i>Д. Оюунсүрэн</i>	
Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах асуудалд	46
<i>Т. Төмөрхүлэг</i>	
БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхэд АНУ үл татгалзаж Тайвань хориг тавиагүйн цаад шалтгаан	63
<i>Д. Энхцэцэг</i>	
Зүүн хойд Ази ба Чингис хааны төрийн ураг барилдах ёсон	66
<i>У. Эрдэнэсанаа</i>	
Монгол-Германы харилцаа: боломж ба бололцоо	70

II. Олон улсын эдийн засгийн харилцаа

<i>А.Батцэцэг</i>	
Хятадын юаний ханшны өөрчлөлт Монгол улсад нөлөөлөх нь	79
<i>Ш. Болормаа</i>	
Дэлхийн аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага 2020.....	83
<i>Д. Намсрай</i>	
Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудын тулгамдсан асуудлууд	87
<i>М.Төмөрбат</i>	
Олон улсын бизнес инкубацийн хөгжлийн бодлого зохицуулалтын туршлагыг Монгол улсын жижиг дунд үйлдвэрлэлд хэрэгжүүлэх асуудалд	92
<i>Д.Тунгалаг</i>	
Дэлхийн хүн амын өсөлтийн “тэсрэлт”	102
<i>Н. Улаан-Од</i>	
Өвөр Монгол болон Монгол улсын мал аж ахуйн салбарт хамтран ажиллах боломжийн тухай өгүүлэх нь	106
<i>С. Энхцэцэг</i>	
Монгол улс, ОХУ-ын худалдаа, эдийн засгийн харилцааны өнөөгийн байдал	110

III. Олон улсын эрх зүй

<i>Ж. Баттогтох</i>	
Био ёс зүй ба хүүхдийн эрх	121
<i>Ц. Жигмиддорж</i>	
Тогтвортой хөгжил, түүнд Киотогийн протоколын гүйцэтгэх үүрэг	126

IV. Хэл, соёлын харилцаа

<i>Б. Боргилмаа</i>	
Хүний бие эрхтний нэр орсон япон, монгол өвөрмөц хэлцийг харьцуулах нь	133
<i>У. Лхагвасүрэн</i>	
Олон үндэстний дохио зангаа нь ёс суртахууны соёлын илэрхийлэл болох нь	137
<i>Г. Цэвэлсүрэн</i>	
“Монголын нууц товчоо”-г франц хэлнээ орчуулсан нь	142

IV. Дурсамж

<i>С. Энхцэцэг</i>	
Хагас зуун жил хөдөлмөрлөж яваа нэгэн буурлын тухай	147

БНХАУ: ХӨГЖИЛ РҮҮ ЧИГЛЭСЭН ГАДААД БОДЛОГООС ДЭЛХИЙ РҮҮ ЧИГЛЭСЭН ГАДААД БОДЛОГО

Н.Алтанцэцэг*

Хятад улс нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх, юуны өмнө дэлхийн хүн амын тавны нэг болох 1,3 тэрбум хүн амыг хооллох, хувцаслах, боловсрол олгох, амьдралын түвшинг дээшлүүлэх зорилт тавин хэрэгжүүлж эхэлсэн нь саяхан. Энэ зорилтдоо хүрэхийн тулд тодорхой шат дараалсан зорилгуудыг дэвшүүлж, гаргасан шийдвэрээ амьдрал дээр ягштал биелүүлсээр өдгөө дэлхийн эдийн засгийн хүчирхэг гүрэн болохыг зорин хөгжиж байна. Энэхүү зорилго, зорилтоо биелүүлэхийн тулд гадаад хүчин зүйлийг, өөрөөр хэлбэл гадаад харилцааг үр өгөөжтэй ашиглах стратеги, тактик боловсруулан хэрэгжүүлж ирсэн онцлогтой. Өөрийн улс орны хөгжлийн төлөөх гадаад бодлого явуулахдаа улс орны бие даасан байдал, тусгаар тогтнолоо хамгаалах асуудлыг гадаад бодлогынхоо нэн тэргүүний зорилт болгон өвлүүлэн залгамжилж ирсэн. Хятад улс бие даасан байдал, тусгаар тогтнолоо хамгаалах зарчмыг нэн тэргүүнд тавих болсон нь өөрийн туулсан зам, алдсан алдаа, түүхэн сургамжаас үүдэн гарсан.

Олон зуун жил Хятад орныг дэлхийн төв хэмээн үзэж, феодалын хамжилгат нийгмийг цогцлон хөгжүүлж байсан орон XIX зууны II хагасаас эхлэн гадаадын колони орон болж хувирсан юм. 1840 онд Английн зэвсэглэсэн усан онгоцууд Хятадын өмнөд эрэгт ирж, Хар тамхины дайн дэгдээсэн үеэс Франц, Орос, Япон, Герман, АНУ Хятадад нэвтрэн орж Хятад орны аюулгүй байдал, тусгаар тогтнолыг ихээхэн ганхуулах болсон. 1840-1949 оны хооронд дээрх империалист гүрнүүд 1175 тэгш бус гэрээг Хятадад тулган хүлээлгэсэн байдаг.¹ Бараг зуу шахам жил Хятад орон хагас колони, хагас феодалын нийгэмд оршиж байсан. Энэ үеийг Хятадын гадаад бодлого, дипломатын түүхэнд хамгийн доромжлол хүлээсэн үе гэж үздэг.

Хятадын ард түмэн улс орноо гадаадын түрэмгийллээс чөлөөлөх тэмцэлд хүчээ нэгтгэн, тухайн үеийн ХКН, Гомиьдан нам эвсэн ард түмнээ зэвсэгт тэмцэлд уриалан дуудаж, 28 жил тасралтгүй тэмцсээр гадаадын түрэмгийллээс эх орноо чөлөөлж чадсан. 1949 онд БНХАУ байгуулагдсанаар Хятадын дипломат ажиллагааны шинэ үе эхэлсэн. Энэ үеэс эхлэн гадаад бодлогынхоо гол зарчмыг тусгаар тогтнолоо хамгаалах, бие даасан байдлыг эрхэмлэх зорилго болгон дэвшүүлж ирсэн. БНХАУ-д ардын хувьсгал ялсны дараа 1949 оны 9-р сарын 21-30-нд Бээжинд Хятадын Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн анхны бүгд хурал хуралдаж, гадаад бодлогоо “БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн зарчим нь

* МУИС, ОУХС-ийн профессор, доктор (Ph.D)

¹ Zhongguo waijiao /Хятадын дипломат ажиллагаа/. Бээжин, 2005, т. 4

тусгаар тогтнол, эрх чөлөө, газар нутгийн бүрэн бүтэн байдал, бие даасан байдлыг хамгаалах явдал бөгөөд даян дэлхийн энх тайван, найрсаг харилцааг эрхэмлэгч бүх улс оронтой найрсаг харилцаатай байж дайн, империалист түрэмгийллийг эрс эсэргүүцэх явдал юм” гэж тодорхойлсон байдаг.

Энэ үеийн дотоод бодлогын гол зорилт нь Хятад улсыг сэргээн босгох явдал байв. Тухайн үеийн олон улсын харилцаа нь ЗХУ-аар толгойлуулсан социалист лагерь, АНУ-аар толгойлуулсан капиталист лагерийн хоорондын тэмцлээр тодорхойлогдож байв. Энэ нөхцөлд БНХАУ ЗСБНХОУ болон бусад социалист улс орнуудтай харилцаагаа хөгжүүлэх, АНУ-ын өдүүлсэн аливаа түрэмгий дайн, түрэмгийллийн эсрэг тууштай тэмцэх явдлыг гадаад бодлогынхоо гол чиглэл болгож байв. Учир нь тухайн үед АНУ шинээр байгуулагдсан БНХАУ-ыг хүлээн зөвшөөрөхгүй, харин ч гоминьданы засгийн газрыг дэмжих бодлого баримталж байв. Харин ЗХУ ХКН-ыг дэмжиж Хятадад коммунист хувьсгал ялуулах, улмаар социализм байгуулах зорилтыг тулган хүлээлгэж байв. 1949-1960 оны эхэн хүртэл БНХАУ, ЗХУ “ах дүүгийн найрамдалт” харилцаатай байв.

Гэвч жараад оны эхэн үеэс ЗХУ, БНХАУ-ын харилцаа муудаж, хоёр том гүрэн бие биенээ “жанжлах” бодлого явуулж байна гэж шүүмжилж, социалист системийн хоёр том улсын хооронд хагарал гарсан. Энэхүү хагарлыг АНУ өөртөө ашигтайгаар, өөрөөр хэлбэл Хятадыг өөрийн талд татаж Зөвлөлтийн эсрэг тэмцэлд ашиглах тактик хэрэглэх болов. 1967 оноос эхлэн АНУ-ын Ерөнхийлөгч Р.Никсон “Хятадтай харилцаагаа сайжруулах” хэрэгтэйг удаа дараа цохон тэмдэглэж байв. Энэ үеийн Хятадын удирдагч Мао Зэдун, Чжоу Энълай нар ч Америкийн саналд нааштайгаар хандаж, Америк-Хятадын харилцааг цаашид хөгжүүлэх анхны суурийг тавьсан. Төдөлгүй 1972 оны 2-р сард Р.Никсон БНХАУ-д анхныхаа албан ёсны айлчлал хийсэн.

Өнгөрсөн зууны 80-аад оны эхээр АНУ, ЗХУ-ын сөргөлдөөн дээд цэгтээ хүрч ирэхэд БНХАУ АНУ-г хэт дагах гадаад бодлогоос болгоомжилж ЗХУ болон харилцаагаа тасалсан байсан бусад социалист оронтой харилцаагаа сэргээх нь чухал гэдгийг ухамсарлаж, Хятадын гадаад бодлогод хоёр өрсөлдөгч лагерийн аль алинтай нь харилцаатай байх зарчмын шинэ өөрчлөлт гарсан. Чингэхдээ АНУ болон ЗХУ-ын аль алиных нь дэлхийд жанжлах үзлийн эсрэг байх бодлого баримтлах болов. Энэ нөхцөл байдалд Баруун Европ, Япон эдийн засгийн хувьд хүчирхэгжиж, хөгжиж байгаа орнууд ч хөгжлийнхөө гольдролд орж эхлэв. Олон улсын тавцанд ч олон туйлт хөгжлийн хандлага ажиглагдаж эхлэв. Энэ үед Хятадын удирдагч Дэн Сяопин “Хятадын үйл хэргийг бодит байдалтай нь уялдуулж явуулах, Хятадын ард түмний өөрсдийнх нь хүчинд тулгуурласан хараат бус, бие даасан бодлого явуулах нь манай үйл ажиллагааны гол үндсэн байр суурь байх ёстой”² гэж хэлж байсан. Дэн Сяопин социалист шинэчлэлийг хурдацтай хөгжүүлэх, эх орноо нэгтгэх /Сянган, Аомынь, Тайвань/, жанжлалтай тэмцэх гэсэн үндсэн гурван зорилтыг дэвшүүлж байв. 1982 онд баталсан БНХАУ-ын Шинэ үндсэн хуулинд БНХАУ биеэ даасан гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлнэ, гадаад бодлогын таван зарчмыг тууштай баримтална, империализм, жанжлах үзэл, колончлолын эсрэг тууштай тэмцэнэ, дарлагдсан болон хөгжиж байгаа орнуудын ард түмэнд тусламж үзүүлнэ хэмээн заасан байдаг.

Энэ үеэс хойш Хятадын гадаад харилцаа хурдацтай хөгжиж 1985 он гэхэд 133 оронтой дипломат харилцаа, 190 гаруй орон, бүс нутагтай эдийн засаг,

² Zhongguo gongchangdan di shier dahui /ХКН-ын XII хурал. Дэн Сяопины тавьсан илтгэл/. 1982 он 12 сар

худалдаа, шинжлэх ухаан техник, соёлын харилцаа тогтоосон байна. Дэн Сяопин өөрчлөлт шинэчлэл нээлттэй бодлогын хүрээнд “Хятад улс удаан хугацааны нээлттэй бодлого явуулна. Чингэхдээ эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техникийн солилцоо харилцааг өргөн хөгжүүлнэ” гэж онцолсон байдаг.

Өнгөрсөн зууны 90-ээд онд олон улсын харилцаанд эрс өөрчлөлт гарч, хоёр туйлт бодлого үндсэндээ устаж, дэлхийн хүчний харилцаанд шинэ шинэ тулах цэгүүд гарч ирэх болсон. Ялангуяа эдийн засгийн эрч хүчээ авч байгаа Хятад, Энэтхэг зэрэг хөгжиж байгаа орнууд дэлхийн эдийн засагт тодорхой байр суурийг эзлэх болсноор гадаад харилцаандаа ч шинэчлэл хийж эхэлсэн. БНХАУ нэн тэргүүнд хөрш орнуудтай сайн хөршийн харилцаатай байх бодлого баримтлах болсон. Мөн хөгжиж байгаа орнуудтай харилцаа, нягтралыг эрчимжүүлэх явдлыг чухалчилсаар ирсэн. Яагаад гэвэл Хятад өөрийгөө хөгжиж байгаа орон гэж үзэн бусад хөгжиж байгаа орнуудын нэгэн адил эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэж, одоо ч улс орноо хөгжүүлэхийн тулд адилхан саад бэрхшээлтэй учирч байгаа, улс орноо хөгжүүлэх нэгэн зорилготой гэж үздэг. Нэгэн зорилго гэдэг нь нэн тэргүүнд улс эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх явдал гэж үзэж байна. Иймээс хөгжиж байгаа орнуудтай өргөн хүрээтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлэх явдлыг гадаад бодлогын гол стратеги гэж үздэг. Гадаадын зарим судлаачид Хятад улс хөгжиж байгаа орнуудын дунд байр сууриа бэхжүүлж “гурав дахь ертөнцийн толгойлогч” болохыг эрмэлзэж байна ч гэж шүүмжилдэг. Гэвч дан ганц хөгжиж байгаа орнуудтай харилцаагаа хөгжүүлэх нь Хятадын эдийн засгийн хөгжилд төдийлэн нэмэр болохгүй тул хөгжингүй орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийг чухалчлах болсон. Чингэхдээ тэдний санхүү, эдийн засгийн хүчин чадал, техник технологийг ашиглах, хөрөнгө оруулалтыг Хятадын эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор татах бодлогыг хэрэгжүүлэх болсон. Үүний улмаас гадаад бодлогодоо нийгэм, соёл, үзэл суртлын ялгааг үл харгалзан хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьж, аливаа санал зөрөлдөөнтэй асуудлыг яриа хэлэлцээ, зөвлөлгөөний замаар шийдвэрлэх дипломат ажиллагааг эрхэмлэх болсон.

Энэ зууны эхэн гэхэд БНХАУ-ын гадаад бодлогод түүний залгамж нэгдмэл чанар болох Хятадын бие даасан хараат бус байдлыг хамгаалах асуудал нэн тэргүүнд тавигдсан хэвээр байгаа боловч Хятадын өөрийнх нь дотоод бодлого, Хятадын эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн гадаад бодлогыг урьдал болгодог байснаа алгуураар дэлхийн хүчирхэг гүрэн болох, олон улсын үйл амьдралд өөрийн хувь нэмрээ оруулж шийдвэр гаргахад нөлөөлдөг болоод байна.

Гадаад бодлогын өөрчлөлт нь Хятадын эдийн засгийн өсөлтийг дагаад Хятад улс хүчээ авч байгаагаар нягт уялдаатай гарч ирж байна. Хятад улс хөгжингүй улсуудтай эдийн засаг, худалдааны харилцаагаа хөгжүүлэхийг чухалчлахын зэрэгцээ дэлхийд шинэ дэг журам тогтоохын төлөө явж байгаагаа удаа дараа албан ёсоор мэдэгддэг. Энэ нь АНУ-ын нэг туйлт бодлогын эсрэг олон туйлт бодлого бий болгох, түүнд өөрийнхөө байр суурийг баттай эзлэх, бусад улс орныг нэгтгэхэд чиглэгдсэн бодлого руу шилжин орж байна.

Үүний тулд хил залгаа орон, бүс нутагт аливаа асуудлыг хурцатгахгүй байх, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх явдыг эрхэмлэж байгаа боловч бүс нутгийн аливаа асуудал шийдвэрлэхэд Хятад өөрийн гэсэн тодорхой байр суурьтай оролцож бүс нутагт өөрийн байр сууриа бэхжүүлэхийг чухалчилж байна. Хэдийгээр Хятадыг хүрээлэн байгаа ЗХА, Зүүн Ази, Өмнөт Азийн бүс нутаг

хурдтай хөгжиж байгаа ч дэлхийн хамгийн аюултай бүс нутагт тооцогддог. Бүс нутагт их гүрнүүд болох АНУ, ОХУ, Хятад, Японы ашиг сонирхлын тэмцэл байнга явагдаж байдаг. Хятадыг хүрээлэх Төв Ази, Зүүн Ази, Зүүн өмнөд Ази, Өмнөд Азийн бүс нутаг цөмийн зэвсгийн аюул, терроризмын аюултай бүс нутаг. Их гүрнүүд Төв Ази, Номхон далайн бүс нутгийг хамгийн аюултай цэргийн хүчирхэг бүс нутаг болгох үйл явц ажиглагдаж байна. Япон болон Өмнөд Солонгосын эдийн засгийн өрсөлдөөн бүс нутгийн хамтын ажиллагаанд төдийлэн эергээр нөлөөлөхгүй байна. Өөрөөр хэлбэл Хятадтай хамтарч ажиллахаас өрсөлдөх сонирхол илүүтэй байна.

Хэдийгээр ОХУ, БНХАУ дэлхийд шинэ дэг журам тогтоохын төлөө стратегийн түншлэл тогтоосон ч Төв Азийн орнууд, Монгол, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад гэхэд л өөр өөрийн ашиг сонирхлын зөрчилтэй байдаг. АНУ, Хятадын хооронд стратегийн харилцан үл итгэлцэх зарчим үйлчилж байгаа нь зөвхөн хоёр улсын бус бүс нутаг, дэлхийн харилцаанд нөлөөлж байна. Төв Ази, ЗХА болон Ази, Номхон далайн бүс нутагт, мөн Монгол улсад Америкийн хүчин зүйл, нөлөөлөл ихсэхэд Хятад төдийлэн дуртай биш ханддаг.

Зүүн Азийн бүс нутагт Япон-Хятад, Япон-Орос, АНУ-Хятадын улс төрийн ашиг сонирхол зөрчилдөхөөс гадна тэдгээрийн эдийн засгийн хүчирхийллийн мөргөлдөөн явагдаж байна. Мөн хүчтэй цэрэг армитай болохын төлөө аль аль нь хүчин зүтгэж байна. Орос, Энэтхэг зэрэг их гүрнүүд өөр өөрийн ашиг сонирхолтойгоор Хятадтай харилцаж байна. ОХУ Хятадтай харилцахдаа энергийн түүхий эд, цөмийн болон зэвсгийн хамтын ашиг сонирхлыг эрхэмлэж байна. Стокгольмын Олон улсын энх тайвны судалгааны хүрээлэнгийн тооцоолсноор 2003 оны байдлаар дэлхийн цэрэг, армийн зардал болон худалдаанд 950 тэрбум ам. доллар зарцуулагдаж байна гэж тооцоолсон ба одоо ч энэ салбарын зардал улам бүр ихэссээр байна.

Бушийн засгийн газар 2006 онд цэргийн зардалд 441.6 тэрбум ам. доллар төсөвлөн зарцуулсан бол 2007 онд 462.7 тэрбум ам. доллар төсөвлөн зарцуулсан байна. АНУ-ын цэрэг, дайны зардал дэлхийн бусад бүх орны цэрэг, дайны зардлыг нийлүүлсэнтэй адил байна.³ Энэ нөхцөлд Хятад улс бусад их гүрний нэгэн адил өөрийн аюулгүй байдлаа цэрэг зэвсгийн хүчээр хамгаалахад гоц анхаарч байна. Цэргийн зардлаа жил ирэх тусам ихэсгэж байна. Өөрийн улсын цэргийн хүчийг бусад хөгжингүй орнуудтай харьцуулан ихээхэн хоцрогдож байгаад санаа зовж байна. Хятадын Олон улсын стратеги судлалын хүрээлэнгийн захирал Сюн Гуанкай'н үзэж байгаагаар "Хятадын батлан хамгаалах хүч механик, хагас механикжилтын түвшинд байна. Хөгжингүй орнуудын батлан хамгаалах салбар мэдээлэл, мэдээллийн технологийг эрчтэй ашиглаж байна. Энэ хоёрын хооронд ихээхэн ялгаа бий" гэж тэмдэглэсэн байна.⁴

Ирээдүйд батлан хамгаалах хүчийг зузаатгах, хүчтэй орчин үеийн батлан хамгаалахын техник, технологитой болохын тулд хүчтэй эдийн засаг, өндөр хөгжсөн шинжлэх ухаан, ихээхэн мөнгө хөрөнгө, цаг хугацаа шаардах нь зүйн хэрэг. Ийм нөхцөлд Хятад улс аюулгүй байдлын хүрээнд улс орнууд бие биедээ итгэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг хангахдаа энх тайванч яриа хэлэлцээний замаар хамтарч ажиллаж энх тайван тогтвортой байдлыг хангах

³ Antes Roddick, *Take it Personally: How Globalization affects you and powerful ways to challenge it*, London, Harper Collins, 2001, p 110

⁴ Xiong Guangkai. "China's Peaceful Development and International Security"- *Foreign Affairs Journal*, 2007.Dec, p. 122

явдлыг гол хэргсэл болгон дэвшүүлж байна. Үүний тулд өнөөгийн нөхцөлд Хятадын удирдлага энх тайванч гадаад бодлогыг эрхэмлэхийг чухлаас чухалд үзэж байна.

2007 оны 10 сард хуралдсан ХКН-ын 17-р их хурал дээр ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ху Жинтао “Хятад улс бүх нийтийн хөгжил цэцэглэлтийн төлөө харилцан нөхсөн энх тайванч гадаад бодлого, энх тайванч хөгжлийн бүтээн байгуулалтыг баримтална” гэж цохон хэлсэн байдаг. Дөрөвдөх үеийн гэгдэх Хятадын удирдагчид Хятад улс аливаа олон улсын сөргөлдөөнд үл оролцож энх тайвнаар хөгжихийг уриалж, хөгжлийн төлөө олон улсын энх тайванч орчныг бий болгохын төлөө ажиллана гэж олонтаа мэдэгдэж байна. Олон улсын хөгжлийн төлөө эдийн засгийн даяршил, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ өөрчлөлт шинэчлэл, инновацаар дамжуулан тогтвортой хөгжлийн бодлого баримтлахыг чухалчилж байна.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн төрийн зөвлөгч Тан Цзясюань “Хятадын одоогийн хөгжил нь зөвхөн Хятадын 1,3 тэрбум хүн амд ашигтайгаар зогсохгүй дэлхийн зах зээл, хөгжилд ашиг тустай байх болно”⁵ гэж хэлсэн нь Хятад зөвхөн өөрийн хөгжлийн биш дэлхийн хөгжлийн нөлөө бүхий орон болохын төлөө байгааг гэрчилж байна. Гэвч дэлхийн хүчирхэг гүрэн болоход одоогийн Хятадын шинжлэх ухаан-техникийн хоцрогдол, эдийн засгийн хөгжлийн индекс, зарим районы эдийн засгийн хоцрогдол, ядуурал, мөн олон улсын эдийн засгийн амьдралд гарч байгаа саад тотгорууд, улс төрийн болон нийгмийн харилцан өөр систем, үзэл суртлын ялгаа, их гүрнүүдийн өрсөлдөөн саад болсоор байна. Хятадын удирдлага нэн тэргүүнд эдийн засгийн хамтын ажиллагаа, технологийн хамтын ажиллагаа, худалдаа ба хөрөнгө оруулалтыг чөлөөлөх, худалдааны янз бүрийн саад тотгорыг арилгах, гадаад худалдааны арга барилыг эрс өөрчлөхийг зорьж байна. Хятадын бараа таваарын илүүдэл, чанарын шаардлага хангахгүй хямд бараа үйлдвэрлэж байгаа нь олон улсын зүгээс шүүмжлэл хүлээж байна. Хятадын үйлдвэрийн бүтээгдэхүүний чанарын асуудал дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа нөхцөлд үйлдвэрүүдийг брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд гаргах арга хэмжээ авч байна. Импорт, экспортын гадаад худалдааны тэнцвэр бариулахад анхаарч ирсэн. Импортын бараанаас татвар авахдаа өндөр технологи, шаардлагатай багаж төхөөрөмж, цахилгаан эрчим хүч, түүхий эдийг татвараас чөлөөлөх, хөнгөлөх арга хэмжээ авч байна. Гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжихдээ ч чанарын шаардлага тавьж байна. Дэлхийн стандартад тохирсон бараа үйлдвэрлэхийг гол зорилгын нэг болгож байна. Үйлдвэрлэсэн чанартай барааг аваад “дэлхийд гар” гэдэг стратегийг 2002 оноос эхлэн баримталж байна.

Мөн Хятадын улс төр, хүний эрхийн асуудал зэргээс болж өрнөдийн орнууд болон Азийн өндөр хөгжилтэй орнууд Хятадын худалдаанд хориг тавьж байгаад шүүмжлэлтэй хандаж, Хятадыг гадуурхахгүй байх олон талт худалдааны систем бий болгохыг чухалчилж байна. Дэлхийн хамтын хөгжилд хөгжингүй орнууд илүү хариуцлага хүлээх үүрэгтэй гэж тэд үзэж байна. Иймээс Хятад улс болон дэлхийн хөгжингүй орнуудын дунд худалдааны маргаан, зах зээлийн ашгийн маргаан, өрсөлдөөн газар авч байна.

Эдийн засгийн шинэчлэл, нээлттэй бодлого хэргэжүүлэхээс өмнө, өөрөөр хэлбэл яг гучин жилийн өмнө нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний

⁵ Tang Jiaxuan. Working Together to Pursue Peaceful Development and Build a Harmonious World – Foreign Affairs Journal, Beijing, 2007, p. 5

хэмжээгээр Энэтхэг, Пакистан, Кения, Нигер, Замбийн хэмжээнд дэлхийн хамгийн доогуур байранд ордог байсан, дэлхийн нийт ядуучуудын 75 хувь нь Хятадад ногддог байсан бол одоо ДНБ-ий жилийн дундаж өсөлт нь 9 хувь болж, ядуурал 18 хувь болж буурсан байна. Өдөрт нэг ам. доллараас доогуур орлоготой 160 гаруй сая хүн амьдарч байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр Хятад улс дэлхийн 100 гаруй орны дараа орж байна. Жил бүр хөдөөд ажилгүйчүүд, ядуучууд 23-24 саяд хүрч байна. Ойролцоогоор 60 гаруй сая хүнд тусламж, халамж шаардлагатай байна. 100 сая гаруй тариачид ажил хайж байна.⁶

Хятадын эдийн засгийн хурдацтай хөгжил нь гадаад хүчин зүйлээс, өөрөөр хэлбэл прагматик гадаад бодлогоос хамаарахаас гадна Хятадын ард түмний хүчин чармайлт, төрийн ухаалаг бодлогоос ихээхэн хамааралтай явагдаж ирсэн. Хятадын хөгжлийн амжилт нь Хятадын ард түмний эрч хүч, чадавхитай холбоотой гэж Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн орлогч ерөнхийлөгч Жемал Уд-Дин Кассум тэмдэглэсэн байдаг.

Хятад өнөөдөр гадаадын хөрөнгө оруулагчдын болон экспортын том зах зээл болон хувираад байна. 700 тэрбум ам. долларын нөөцтэй бөгөөд Японы дараа хоёрдугаарт орж байна. Эдийн засгийн нээлттэй бодлого явуулахдаа гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын үнэ тарифыг хуульчилж захиргааны хяналтанд авсан. Дэлхийн эдийн засагт Хятадын байр суурь улам бэхжиж, дэлхийн эдийн засгаас жилд 40 тэрбум ам. долларын ашиг олж байна. Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсноор дэлхийн худалдааны системээс асар их ашиг олж байгаа ба хойшид ч дэлхийн худалдааны либералчлалд чухал үүрэг гүйцэтгэх болно. Дэлхийн банк Хятадын эдийн засгийн хөгжлийг гадаадын хөрөнгө оруулалтын орчин сайн бүрдүүлсэн, худалдааг чөлөөлсөн, харилцан тэгш боломжийг гадаадынханд олгосон гэсэн гурван хүчин зүйлээр тодорхойлж байна.

Хятадын нийгэмд өнөөдөр тулгамдаж байгаа гол асуудал бол ядуурал, бүс нутгуудын хөгжлийн тэгш бус байдал, баян, ядуугийн ялгаа ихсэж байгаа, боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх зэрэг юм. Түүхий эдийн хомсдол, нефть, байгалийн баялаг, төмөр, хөнгөн цагаан, молибден, мөн газар, цэвэр усны дутагдалтай тулгарч байна. Иймээс гадаад орнуудаас түүхий эд авах, эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх, түүхий эд болон эрчим хүчний нөөцийг хуримтлуулах явдлыг чухалчилж байна. Иймээс эдгээр дутагдсан зүйлийг Монгол зэрэг Ази, Африкийн орнуудаас авах сонирхол их байгаа. 2004 оны байдлаар Хятадад дэлхийн нийт нефтийн хэрэглээний гуравны нэг, металлийн хэрэглээний тал хувь хэрэгцээтэй байгаа тооцоо гарсан. Хятадын нийгмийн хангамж, эдийн засгийн хэрэгцээ улам ихсэж байгаатай уялдан Ази, Африк, Латан Америкийн хөгжиж буй орнуудтай харилцаагаа эрчимтэй хөгжүүлэхийг зорьж байна. Хятад улс Африкийн 53 орны 46-тай нь дипломат харилцаа тогтоогоод байна. Хятад Африкт явуулж буй бодлогодоо империализм, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг тэдний тэмцлийг тууштай дэмжиж, эдийн засгийн хөгжилд нь туслахаа илэрхийлж байна.⁷ 2006 оны байдлаар Хятад улс Африкийн орнуудын хоёр талын худалдаа 40 тэрбум ам. долларт хүрээд байна. 2007 оны 5 сард Хятад улс, Африкийн хөгжлийн сан 1 тэрбум ам. долларын хөрөнгөтэй байхаар баталсан ба төдөлгүй энэ санг 5 тэрбум ам. долларт хүргэх зорилт тавьж

⁶ Xiong Guangkai. "China's Peaceful Development and International Security" - *Foreign Affairs Journal*, 2007, Dec, p. 120

⁷ Farah Arbab. "China-Africa Interaction: Prospects for a Strategic partnership" in *Strategic Studies*, Autumn 2007, Institut of Strategic Studies, Islamabad

байна.⁸ 2006 оны 11 сард Хятад улс Бээжинд Африкийн 48 улсын тэргүүн нарын уулзалтыг зохион байгуулж, энэ уулзалтаар Хятад, Африкийн орнуудын харилцааг бүх салбарт хөгжүүлэх, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхүү анхаарах болсон байна.

Хятад улс Латин Америкийн орнуудтай харилцаагаа хөгжүүлэхэд анхаарч 2005 оны байдлаар худалдааг 50 тэрбум ам. долларт хүргэсэн байна. Өмнөд Америкийн орнууд, тухайлбал Куба, Жамайка, Болив, Чили, Аргентин, Уругвай, Эквадор, Перу, Барбадос улсуудтай хөрөнгө оруулах гэрээнд гарын үсэг зураад байна.⁹ Хятад улс Коста Рика улстай 2007 оны 6 сарын 1-нд дипломат харилцаа тогтоогоод байна. Энэ нь Латин Америкийн орнууд Хятадтай тогтоосон болон хөгжүүлж буй харилцаанд ихээхэн найдвар тавьж байгаагийн илрэл болж байна.

2002 оноос “дэлхийд гарах” стратеги баримталж ирсэн нь Хятадын хөрөнгө оруулалт, үйлдвэрийн газруудыг гадаадад байрлуулах зорилго агуулж байна. Зүүн өмнөд Азийн буурай хөгжилтэй Лаос, Камбодж, Мьянмар, Вьетнам зэрэг орнуудад Хятадын хөрөнгө оруулалт ихээхэн орж ирж байна. АСЕАН-ы орнуудад 5 тэрбум хөнгөлөлттэй зээл Хятадын компаниудыг дэмжих зорилгоор олгох болсон нь хойшид ч энэ хандлага газар авах шинжтэй болсныг харуулж байна.¹⁰ Малайзын хувьд П Пенанийн гүүр барихад хөрөнгө оруулж зохион бүтээх ажлыг Хятадын тал хийж байна. Хятад АСЕАН-ы орнуудтай чөлөөт худалдааны гэрээ байгуулах зорилготой ажиллаж байна. Хятад Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгт (South Asian Association for Regional Cooperation) ажиглагчийн статустай оролцож байна.

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж эхэлснээс хойш 1978 оноос 2006 оны хооронд дотоодын нийт бүтээгдэхүүн жилд дунджаар 9%-ийн өсөлттэй байсан бөгөөд нийт ард түмэн хооллох, хувцаслах хэрэгцээгээр хангагдаж, амьжиргаа дундаж түвшний хэмжээнд хүрсэн. 2006 онд үндэсний нийт бүтээгдэхүүн 2,626.9 тэрбум ам. долларт хүрч дэлхий дээр 4-р байранд орсон. Нийт гадаад худалдаа 1,760 тэрбум ам.долларт хүрч дэлхийд 3-р байранд орсон. Гадаад валютын нөөц 1066.3 тэрбум ам.долларт хүрч дэлхийд тэргүүлэх болов.¹¹ Өнөөдөр Хятад эдийн засгийн (PPP Purchasing Power Parity) үзүүлэлтээр АНУ-ын дараа хоёрдугаарт орж байна. Худалдаагаар АНУ, Германы дараа 3-т орж Японыг ардаа орхиод байна. Хятадын нийт худалдаа 2007 оны байдлаар 2.1 триллион ам.долларт хүрсэн ба экспорт 1.2 триллион ам. доллар байна. Импорт 950 тэрбум. ам доллар байна.

2000 оны байдлаар нэг хүнд ногдох ҮНБ 800 ам. доллар байсан бол 2006 онд 2000 ам. доллар болж өссөн байна. 2020 он гэхэд 2000 оныхтой харьцуулахад нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүнийг 4 дахин өсгөх зорилт тавьж байна.

Өөрчлөлт шинэчлэлтийн бодлого хэрэгжүүлсний 30 жилийн хугацаанд Хятадын эдийн засаг дэлхийн эдийн засгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон бөгөөд дэлхийн эдийн засгийн гол үүрэг гүйцэтгэгчийн нэг болоод байна. Олон улсын эдийн засгийн бүтээн байгуулалтын идэвхтэй оролцогч нь, зохицуулагч нь болоод байна. Өөрийн орны эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийн эдийн засагт чухал хувь нэмэр оруулж байна.

⁸http://www.chinadaily.com.cn/china/2007-05/14/content_871632.htm

⁹<http://www.chiese-embassy.org.uk/eng/zt/Features/t274353.htm>

¹⁰ Dato' Abdul Majid Ahmad Khan. P. 66

¹¹ Xiong Guangkai. “China's Peaceful Development and International Security”- Foreign Affairs Journal, 2007.Dec, p. 120

Одоогийн байдлаар Хятад улс дэлхийн эдийн засгийн өсөлтөнд 10 % эзэлж байна.¹² 2007 оны Дэлхийн банкны судалгаагаар Хятад улс дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний 16%-ийг эзэлж АНУ-ын дараа орж байна. 2003-2005 оны байдлаар дэлхийн худалдааны 15%-ийг эзэлж АНУ-тай эн тэнцүү хэмжээнд хүрчээ. Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээр Хятад 500 тэрбум ам. долларын бараа импортолж байгаа ба ойрын үед 800 тэрбум ам долларт хүрч 2010 онд 1 триллион ам. долларт хүрэх тооцоотой байна.

Хятадын гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж чадаж байгаагийн гол хүчин зүйлүүд нь том зах зээлтэй, хөдөлмөрлөх хүчний нөөцтэй, хямд бүтээгдэхүүнтэй, эдийн засаг, нийгмийн тогтвортой орчинг бий болгосон явдал юм. Одоогийн байдлаар дэлхийн топ 500 хөрөнгө оруулагчдын 400 нь Хятадад хөрөнгө оруулж байна.¹³

Хэдийгээр дээрх ололттой талууд байгаа боловч дэлхийн хамгийн олон хүн амтай Хятад улсын хувьд эдийн засгийн хүчирхэг гүрэн болоход тулгарч байгаа нийгэм, эдийн засгийн асуудлууд бишгүй их бий. Тухайлбал, хүний өсөлтийг хязгаарлах, ард түмний боловсролын түвшинг дээшлүүлэх, хүний хөгжил, амьдралын орчинг сайжруулах, шинжлэх ухаан, инноваци, сансар судлалыг хөгжүүлэх, түүхий эд, эрчим хүчээр улс орны хэрэгцээг хангах, батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.

Гэвч өнөөгийн Хятадын эдийн засгийн хөгжил олон улсын анхаарлыг татаж, дэлхийн хөгжил, олон улсын харилцаанд зарчмын өөрчлөлт оруулах нь дамжиггүй болоод байна. Эдийн засгийн хөгжлөө дагаад Хятадын гадаад бодлого ч хувьсан өөрчлөгдөж, дэлхийд нөлөө бүхий том гүрэн болоод байна. 2004 оны байдлаар 165 оронтой дипломат харилцаатай, 135 олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцдог, 220 гаруй оронтой эдийн засаг-соёлын харилцаатай, 152 оронтой шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж байна¹⁴. Өнөөгийн Хятадын хөгжил, түүний дэлхийн олон улсын харилцаанд оруулж буй өөрчлөлтийг Америкийн зарим улс төрчид, дипломатууд “дэлхий дээр өнөөдөр соёл иргэншлийн гэхээсээ хөгжлийн төлөөх үзэл баримтлал, үзэл суртлын ялгаа улам их болж байна”¹⁵ гэж дүгнэсэн байна. Өнөөгийн Хятад улс ОХУ, АНУ зэрэг их гүрнүүдийн дэлхийд нөлөөнийхөө хүрээг ихэсгэх тэмцэлд хүч түрэн орж ирж, өөрийнхөө нөлөөний хүрээнд юуны өмнө хөрш орнууд, Ази, Африкийн хөгжиж буй орнууд, өөрийг нь хүрээлэх бүс нутгийг оруулах бодлогын төлөө дипломат ажиллагаа эрчимтэй явуулж байна.

¹² Du Ying. *Stick to Peaceful Development and Build A Harmonious World*. Foreign Affairs Journal, Beijing, 2007, p. 23

¹³ Мөн тэнд, тал 24

¹⁴ Zhongguo waijiao /Хятадын дипломат ажиллагаа/. Бээжин, 2005, т. 11

¹⁵ J. Stapleton Roy. /Former US Ambassador to China/. *Prospect of China's Peaceful Development*, Foreign Affairs Journal, Beijing, 2007, p. 29